



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

᠒᠐᠒3 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/᠒31

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх заалт, ШУА-ийн дүрмийн 22 дугаар зүйлийн “з” дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шинжлэх Ухааны Академийн харьяа хүрээлэнгийн судлаачдаас олон улсад нэр хүндтэй мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд бүтээл нийтлүүлсэн судлаачдад мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дарга (А.Баярбаатар)-д даалгасугай.


ЕРӨНХИЙЛӨГЧ



Д.РЭГДЭЛ

Шинжлэх ухааны Академийн
Ерөнхийлөгчийн 2023 оны 12
дугаар сарын 28 өдрийн
дугаар тушаалын хавсралт

А.7
231



Олон улсын нэр хүндтэй мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд бүтээл нийтлүүлсэн судлаачдад мөнгөн урамшуулал олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Олон улсын нэр хүндтэй мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн, гадаад хэл дээр ном, номын бүлэг туурвисан, олон улсын патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу (PCT) патентын мэдүүлэг гаргасан судлаачдад мөнгөн урамшуулал олгоход энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Энэхүү урамшууллын зорилго нь ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн судалгаа хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх, судлаачдын идэвхийг нэмэгдүүлэх, судалгааны чанарыг сайжруулж олон улсын түвшинд хүргэх, шинэ мэдлэг, мэдээллийг шинжлэх ухааны эргэлтэд оруулахад оршино.
- 1.3 Мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын төсөвт жил бүр тусгана.
- 1.4 Урамшуулалд олон улсын мэдээллийн сан "Scopus" болон "Web of Science" (WoS)-д бүртгэлтэй импакт фактор (IF) бүхий мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн, гадаадын нэр хүндтэй хэвлэлийн газарт гадаад хэлээр ном, номын бүлэг хэвлүүлсэн, олон улсын (PCT) патентын мэдүүлэг гаргасан судлаачдыг нэр дэвшүүлнэ.
- 1.5 Урамшууллыг ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар жилд нэг удаа Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан олгоно.

Хоёр. Урамшууллын төрөл

2. Урамшууллыг дараах судлаачдад олгоно.
 - 2.1. 1.0-ээс дээш импакт фактор бүхий мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн зохиогч;
 - 2.2. Нэр хүндтэй хэвлэлийн газраас гадаад хэл дээр туурвисан ISBN дугаартай ном, номын бүлгийн зохиогч;
 - 2.3. Олон улсын патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу (PCT) патент мэдүүлсэн судлаач.

Гурав. Урамшуулал олгох болзол

- 3.1. Хамтарсан өгүүлэл хэвлүүлсэн судлаачид тавигдах шаардлага:
 - 3.1.1. Хамтарсан өгүүллийн урамшууллыг зөвхөн нэгдүгээр болон хариуцлагатай зохиогч нарт олгоно.

- 3.1.2. Хамтарсан өгүүлэл нь олон улсын мэдээллийн сан “Scopus” болон “Web of Science” (WoS)-д индекстэй, 1.0-ээс дээш импакт фактортой сэтгүүлд хэвлэгдсэн байх шаардлагатай бөгөөд үүнд хуурамч (предатор) сэтгүүлүүд хамаарахгүй.
- 3.1.3. Бүтээлийн нэгдүгээр болон хариуцлагатай зохиогч ижил байх тохиолдолд хариуцлагатай зохиогчийн урамшууллыг олгоно.
- 3.2. Нэгэн сэдэвт бүтээл туурвисан судлаачид тавигдах шаардлага:
- 3.2.1. Зөвхөн ISBN дугаартай олон улсад нэр хүндтэй хэвлэлийн газарт гадаад хэл дээр хэвлэгдсэн ном, номын бүлгийн зохиогчид урамшууллыг олгоно.
- 3.3. Олон улсын патентад тавигдах шаардлага:
- 3.3.1. Өөрийн судалгааны чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад зохих журмын дагуу (PCT) патентын мэдүүлэг гаргасан байх.

Дөрөв. Урамшууллын хэмжээ

- 4.1. Урамшууллын хэмжээ нь сэтгүүлийн чанараас хамааран ялгаатай байна (Хүснэгт 1.).
- 4.2. Гадаад хэл дээр нэгэн сэдэвт бүтээл, ном хэвлүүлсэн болон олон улсын PCT патентын мэдүүлэг гаргасан судлаачдад олгох урамшууллыг 10-аас дээш, номын бүлэг хэвлүүлсэн зохиогчид олгох урамшууллыг 4-6 импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлсэн хариуцлагатай зохиогчийн бүтээлтэй дүйцүүлэн үнэлнэ.

Хүснэгт 1. Судлаачдад олгох урамшууллын хэмжээ /мян.төг/

Импакт фактор	Нэгдүгээр зохиогч	Хариуцлагатай зохиогч
1-3	300.0	500.0
4-6	500.0	700.0
7-9	700.0	1,000.0
10-дээш	1,000.0	1,500.0

Тав. Шагналд нэр дэвшүүлэхэд дагалдах материал

- 5.1. Урамшууллын болзол хангасан судлаач дараах материалыг бүрдүүлэн тухайн оны 11 дүгээр сарын 15-ны дотор ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт ирүүлнэ. Урамшууллын материалыг хугацаа хожимдуулсан, дутуу бүрдүүлсэн тохиолдолд хүлээн авахгүй бөгөөд тухайн байгууллагад буцаана.
- 5.1.1. Бүтээлийн монгол хэл дээрх товч танилцуулга;
- 5.1.2. Бүтээлийн хуулбар;
- 5.1.3. Хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлын тогтоол, тэмдэглэл;

- 5.1.4. РСТ патентын мэдүүлэг гаргасан баримтын хуулбар;
- 5.2. Бүтээлийг өмнөх оны 11 дүгээр сарын 16-аас тухайн оны 10 дугаар сарын 31-ний хооронд хэвлүүлсэн байх шаардлагатай.

Зургаа. Шагналыг олгох зарчим, нөхцөл

- 6.1. Эрдэм шинжилгээ, мониторингийн хэлтэс урамшууллын материалын журмын дагуу нягтлан үзэж, удирдлагад танилцуулга хийнэ.
- 6.2. Урамшууллаас холбогдох татварыг суутган авч судлаачдын дансанд шилжүүлэн олгоно.
- 6.3. Шагналын материалыг буцаан олгохгүй, архивын нэгж болгон хадгалуулна.
- 6.4. Мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, тухайн оны урамшуулалд хамрагдахаар ирүүлсэн материалыг архивд шилжүүлэх ажлыг Эрдэм шинжилгээ, мониторингийн хэлтэс хариуцна.

--- ооОоо ---